



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА



Арвайхээр хот
2022 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2021
ОНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТАНИЛЦУУЛГА

ТАНИЛЦУУЛГЫГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Н.Даваатогтох Статистикийн хэлтсийн мэргэжилтэн

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

О.Түмэнжаргал Статистикийн хэлтсийн дарга

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Өвөрхангай аймаг, Арвайхээр сум
Нутгийн удирдлагын ордон, 403 тоот
Утас: 70323442
Цахим хуудас: <https://uvurkhantai.nso.mn>
И-мэйл: uvurkhantai@nso.mn

Арвайхээр хот
2022 он

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ	x
ОРШИЛ	7
II.1. Малтай өрх, малчин өрхийн тоо, байршил	9
II.2. Малчин өрхийн соёл ахуйн зарим үзүүлэлт	10
III.МАЛЧДЫН МЭДЭЭЛЭЛ	11
III.1. Малчдын тоо	11
III.2. Малчдын нас, хүйс.....	11
III.3. Үндсэн болон туслах малчин	12
III.4. Малчдын боловсролын түвшин	13
III.5. Малчдын нийгмийн даатгал, ЭМД-ын хамрагдалт	14
III.6. Малчдын гар утас болон интернэтийн хэрэглээ	15
III.7. Зээлтэй малчид.....	16
IV. МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ.....	17
IV.1 Малын тоо	17-18
IV.1.1. Малын тоогоор тэргүүлсэн сумд.....	18
IV.2. Өрхийн аж ахуйн болон аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо	19
IV.3. Малтай өрхийн бүлэглэлт.....	20-21
IV.4 Сүргийн бүтэц	21-22
IV.5 Хээлтэгч мал.....	22-23
IV.6 Төл бойжилт	23-24
IV.7 Хээл хаялт, сувайралт	24-25
IV.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо.....	26
IV.9 Малын хэрэглээний зарлага	27
IV.10 Хүнсний хэрэглээ	28
IV.11 Том малын зүй бус хорогдол.....	29-30
IV.12 Тэжээвэр амьтад	31
V. ГАЗАР ТАРИАЛАН.....	32-33
V.1 Тариалсан талбай	33
V.2 Хураасан ургац.....	33
ДҮГНЭЛТ.....	34-35
ХАВСРАЛТ.....	36

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Мал бүхий өрх гэж малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрхийг ойлгоно.

Малчин өрхөд жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хамруулна.

Малтай өрх гэж мал бүхий өрх болон малчин өрхийг хэлнэ.

Малчид гэж жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж мал аж ахуй эрхлэгчдийг ойлгоно.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр	- 1 бод
1 тэмээ	- 1.5 бод
6 хонь	- 1 бод
8 ямаа	- 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд, шилжүүлэх коэффициент:

1 тэмээ	- 5 хонь
1 адуу	- 7 хонь
1 үхэр	- 6 хонь
1 хонь	- 1 хонь
1 ямаа	- 0.9 хонь

Хонин толгойд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн малд малын төрөл бүрээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ	- 4 ба түүнээс дээш настай
Адуу	- 3 ба түүнээс дээш настай
Үхэр	- 2 ба түүнээс дээш настай
Хонь	- Тухайн жилийн төл малаас бусад насны хонь
Ямаа	- Тухайн жилийн төлөөс бусад насны ямаа

Өсвөр насны мал

Тэмээ	- Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу	- Өмнөр оны төл, 2 настай
Үхэр	- Өмнөх оны төл
Бог мал	- Тухайн жилийн төл мал

Төл малд малын төрөл бүрээрх тухайн жилийн төлийг хамруулна.

Бэлэн хээлтэгчид малын төрөл бүрээрх нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо толгойн өсөлт оны эцсийн малаас оны эхний малыг хасаж, малын тооны өөрчлөлтийг тоогоор

илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулж өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал нь** төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулж тооцно.

Төл бойжилтын хувь бойжуулсан төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж тооцно.

100 эхээс бойжуулсан төл бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо хээлтэгч малын тооц хээлтүүлэгч малын тоонд харьцуулж тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур	- 20-25
Азарга	- 12-15
Бух	- 35-40
Хуц, ухна	- 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулж тооцно.

Малын хэрэглээний зарлага оны эхний мал, бойжуулсан төлийн нийлбэрээс том малын зүй бус хорогдол болон оны эцсийн малын тоог хасаж нийт малын хэрэглээний зарлагыг тооцно.

Малын хашааны хангамж хашааны багтаамжийг малын тоонд харьцуулна. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулж тооцно.

Малын бэлчээрийн даац гэж бэлчээрийн ургамлын өсөлт, хөгжилт, нөхөн сэргэлтэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр тодорхой хугацааны туршид нэг га бэлчээрт бэлчээж болох малын тоог ойлгоно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх итгэлцүүр бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Дараах итгэлцүүрийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Бэлтгэсэн тэжээл	Итгэлцүүр
Гар тэжээл, хужир шүү	1.00
Үр тарианы хаягдал	0.90
Хадлан өвс	0.45
Лай	0.40
Таримал тэжээл	0.35
Даршны ургамал	0.25
Сүрэл	0.25
Төмс ногооны хаягдал	0.22

Малын тэжээлийн ангилал малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл – өвс, сүрэл, нэг наст ба олон наст ургамал
 2. Хүчит тэжээл – үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг
 3. Шүүст тэжээл – Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал тус тус орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг багтана.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай тухайн жилд ургац хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд харьцуулж тооцно.

Нийт ургац тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл нийт тариалсан талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техникийн ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөрх ургацын хэмжээг хэлнэ.

ХАА-н эдийн засгийн бүс 5 бүсэд хувааж, бүс тус бүрд дараах аймаг, нийслэл хамрагдана.

Бүс	Аймаг/нийслэл
Баруун бүс	Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан аймаг
Хангайн бүс	Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг
Төвийн бүс	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг
Зүүн бүс	Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг
Улаанбаатар	Улаанбаатар хот

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, улс орны боловсруулах үйлдвэрийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад зориулагдаж байдаг.

Манай аймгийн эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар гол байр эзэлдэг.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, энэ ч утгаараа мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

Статистикийн тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Статистикийн хэлтэс мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг аймгийн хэмжээнд явуулж үр дүнг нэгтгэн гаргадаг.

Мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнд үндэслэж мал, амьтдын өсөлт, бууралт, сүргийн бүтцэд гарч байгаа өөрчлөлт, мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүний хэмжээг тооцон дүн шинжилгээ хийж, цаашид хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх талаар төр засгийн бодлого боловсруулах, хэрэгжилтийг дүгнэхэд шаардагдах дэлгэрэнгүй мэдээллийг гарган авах, салбарын эдийн засгийн тооцооны тулгуур үндэслэл болдгоороо ихээхэн ач холбогдолтой юм.

Энэхүү танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2020 оны төлөв байдлыг нэгтгэн, мал тооллогын үндсэн үр дүнгээс гадна, малчин өрх, малчдын мэдээлэл, малын хашаа, худаг, уст цэг болон газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг тусгасан болно.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал нь суурь мэдээлэл болно гэдэг итгэж байна.



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

МАЛЫН ТОО, 5 ТӨРЛӨӨР, мянган толгой



МАЛТАЙ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО




II.1 МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО

2021 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогоор 19811 малтай өрх тоологдсон нь аймгийн нийт өрхийн 57.5 хувийг эзэлж байгаа нь өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна. Нийт малтай өрхийн 17838 өрх буюу 90.0 хувь нь жилийн дөрвөн улирлын туршид малаа малладаг, малын ашиг шим нь тэдний амжиргааны эх үүсвэр болж буй малчин өрх, харин 1973 өрх буюу 10.0 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна.

ХҮСНЭГТ 2.1. МАЛТАЙ БОЛОН МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО

Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2020	2021/2020	
						Зөрүү	Хувь
Малтай өрх	18956	19209	19233	19813	19811	-2.0	100.0
Малчин өрх	16087	16307	16398	17464	17838	374.0	102.1
Малчдын тоо	28265	28103	27101	28333	28257	-76.0	99.7
Үүнээс:16-34 насны	10162	9866	8676	8636	8008	-628.0	92.7
35-аас тэтгэвэрт гарах насны	14252	15386	14702	16381	15837	-544.0	96.7
Тэтгэврийн насны	3851	2851	3723	3316	4399	1083.0	132.7
Нийт малчдаас эмэгтэй	12417	12296	11416	11845	16616	4771.0	140.3
Үүнээс:16-34 насны	36	35.1	32	30.5	28.3	-2.2	92.9
35-аас тэтгэвэрт гарах насны	50.4	54.7	54.2	57.8	56.0	-1.8	97.0
Тэтгэврийн насны	13.6	10.1	13.8	11.7	15.6	3.9	133.1
Нэг малчин өрхөд ногдох малын тоо	357	335	343	256	226	-30.0	88.3

Малчин өрхийн ам бүлийн тоо 61735 байгаа ба нэг малчин өрхийн ам бүлийн тоо дунджаар 3.5 байна. 2020 оноос малтай өрх 0.01 хувиар буюу 2 өрхөөр буурч, малчин өрх 2.1 хувиар буюу 374 өрхөөр нэмэгджээ. Нийт малчин өрхийн 1.1-1.8 мянган өрх буюу нийт малчин өрхийн 45.3 хувийг Уянга, Бат-Өлзий, Хужирт, Зүүнбаян-Улаан, Хархорин сумдууд эзэлж байна.



II.2 МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Мал тооллогын 2021 оны нийт дүнгээр малчин өрхийн 80.0 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 72.6 хувь нь телевизортой, 42.4 хувь нь автомашинтай, 54.8 хувь нь мотоциклтой, 0.2 хувь нь трактортой байна.

Цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо 2021 онд 14265 болж, 2020 оныхоос 168 өрх буюу 1.2 хувь, мотоциклтой өрхийн тоо 9769 болж, 2020 оныхоос 218 буюу 2.2 хувиар тус тус буурч, телевизортой өрхийн тоо 12951 болж, 2020 оноос 741 буюу 5.7 хувь, автомашинтай өрхийн тоо 7572 болж, 2020 оныхоос 61 буюу 0.8 хувь, трактортой өрхийн тоо 34 болж, 2020 оныхоос 4 буюу 13.3 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

Нийт малчин өрхөд автомашинтай өрхийн эзлэх хувь 0.6 пункт, цахилгаан үүсгүүртэй өрхийн эзлэх хувь 2.6 пункт, мотоциклтой өрхийн эзлэх хувь 2.4 пунктээр тус тус буурч, телевизортой өрхийн эзлэх хувь 1.5 пунктээр өсөж, трактортой өрхийн эзлэх хувь өмнөх оны түвшинд байна.

ХҮСНЭГТ 2.2.1 МАЛЧИН ӨРХИЙН СОЁЛ АХУЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ


Төрөл	Малчин өрхийн тоо					Малчин өрхийн тоонд эзлэх хувь				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
Цахилгаан үүсгүүртэй	12587	12767	13579	14433	14265	78.2	78.3	82.8	82.6	80.0
Телевизортой	10780	11217	11867	12250	12951	67	68.8	72.4	70.1	72.6
Автомашинтай	4963	5744	7084	7511	7572	30.9	35.2	43.2	43	42.4
Мотоциклтой	8169	8869	10270	9987	9769	50.8	54.4	62.6	57.2	54.8
Трактортой	43	30	37	30	34	0.3	0.2	0.2	0.2	0.2

Нийт цахилгааны үүсгүүртэй өрхийн 88.8 хувь нь нарны, 0.2 хувь нь салхины, 11.2 хувь нь бусад(бага оврын мотор, аккумулятор гэх мэт) төрлийн цахилгаан эх үүсгүүртэй байна.

ХҮСНЭГТ 2.2.2 ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРТЭЙ ӨРХИЙН ТОО, цахилгаан үүсгүүрийн төрлөөр

	Бүгд	Нарны			Салхины			Бусад		
		малчин өрх			дүнд эзлэх					
	2019	2020	2021	2019	2020	2021	2019	2020	2021	
2019	13579	12381	3	1195	91.18	0.02	8.8			
2020	14433	12951	40	1442	89.7	0.3	10			
2021	14265	12665	27	1609	88.8	0.2	11.3			

ЗУРАГ 2.2 ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСГҮҮРТЭЙ ӨРХИЙН ТОО



III.1 МАЛЧДЫН ТОО


Манай аймгийн хөдөлмөрийн насны хүн амын хоёр хүн тутмын нэг нь 2021 оны байдлаар мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байна. Тухайлбал, мал тооллогын 2021 оны дүнгээр 28257 малчид мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Малчдын тоо өмнөх оноос 76 малчин буюу 0.3 хувиар буурчээ.

Малчдын тоог сумаар авч үзэхэд Баруунбаян-Улаан, Баянгол, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Төгрөг, Хайрхандулаан, Хархорин сумдад 1-236 малчнаар буурсан, харин бусад сумдад 1-175 малчнаар өссөн дүнтэй байна.

Бат-Өлзий, Богд, Уянга, Хужирт сумд харгалзан 2299, 2135, 2857, 2042 малчидтай байгаа нь нийт малчдын 33.0 хувийг эзэлж байна.

Баруунбаян-Улаан, Гучин-Ус сумд харгалзан 635, 789 байгаа нь хамгийн бага малчинтай байна.


ЗУРАГ 3.1.1 МАЛЧДЫН ТОО, СУМААР



III.2 МАЛЧДЫН НАС, ХҮЙС


Нийт малчдын 28.4 хувь нь 16-34 насны, 56.0 хувь нь 35-60 насны, 15.6 хувь нь тэтгэврийн насныхан байна. Өмнөх оноос 35-60 хүртэлх насны малчдын нийт дүнд эзлэх хувийн жин 1.8 пунктээр, 16-34 насны малчид 2.1 пунктээр тус тус буурч, 60 ба түүнээс дээш тэтгэврийн насныхан 3.9 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 3.2.1 МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар



Нийт малчдын 16616 нь буюу 58.8 хувь нь эрэгтэй, 11641 нь буюу 41.2 хувь нь эмэгтэй малчид байна. Малчдын дотор эрэгтэй малчид давамгайлж байна. Малчдын тоог хүйсээр авч үзэхэд эрэгтэй малчдын тоо өмнөх оноос 128 буюу 0.7 хувиар өсөж, эмэгтэй малчдын тоо 204 буюу 1.7 хувиар буурсан дүнтэй байна.


ЗУРАГ 3.2.2, 3.2.3 МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, 2021 ОН, насны бүлэг, хүйсээр



III.3 ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧИН

Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлдэг малчдын 97.7 хувь нь 2021 онд үндсэн малчин, 2.3 хувь нь туслах малчид байна. 15-24 насны малчдын 94.4 хувь нь үндсэн малчин бол 5.6 хувь туслах малчин байна. 25 наснаас дээших насны бүлгүүдэд үндсэн малчин 97.6-98.6 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 3.3.1 ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ МАЛЧНЫ ХАРЬЦАА, 2020 ОН



Нийт үндсэн малчдын 71.1 хувь буюу 20098 малчин нь 25-54 насных байна. Харин нийт туслах малчдын 67.8 хувь нь буюу 445 малчин нь 25-54 насных байна.

III.4 МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Малчдын боловсролын түвшинг 2021 авч үзэхэд 31.2 хувь бага, 38.7 хувь нь суурь, 18.9 хувь нь бүрэн дунд, 2.5 хувь нь техник болон тусгай мэргэжлийн, 6.1 хувь нь дээд боловсролтой байгаа бол 2.6 хувь нь боловсролгүй байна.

ХҮСНЭГТ 3.4.1 МАЛЧДЫН БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, 2021 ОН, насны бүлгээр

Насны бүлгээр	Боловсролын түвшин						
		Боловсролгүй	Бага	Суурь	Бүрэн дунд	Техникийн болон тусгай мэргэжлийн	Дээд
Дүн	28257	740	8830	10934	5332	706	1715
15-24	2082	62	411	840	585	84	100
25-34	5939	183	1682	1671	1438	250	715
35-44	8005	262	3326	3021	1113	42	241
45-54	6599	92	1065	3471	1543	165	263
55-64	3591	83	1056	1548	558	122	224
65 ↑	2041	58	1290	383	95	43	172

Насны бүлгээр	Дүнд эзлэх хувь						
	Дүн	2.6	31.2	38.7	18.9	2.5	6.1
Дүн	100	2.6	31.2	38.7	18.9	2.5	6.1
15-24	100	3.0	19.7	40.3	28.1	4.0	4.8
25-34	100	3.1	28.3	28.1	24.2	4.2	12.0
35-44	100	3.3	41.5	37.7	13.9	0.5	3.0
45-54	100	1.4	16.1	52.6	23.4	2.5	4.0
55-64	100	2.3	29.4	43.1	15.5	3.4	6.2
65 ↑	100	2.8	63.2	18.8	4.7	2.1	8.4


Малчдын насны бүлгээр нь авч үзвэл 25-44 насны нийт 13944 малчдын 445 хувь нь буюу 3.2 хувь нь боловсролгүй, 5008 буюу 35.9 хувь нь бага, 4692 буюу 33.7 хувь суурь, 2551 буюу 18.4 хувь нь бүрэн дунд, 292 буюу 2.1 хувь нь техник болон тусгай мэргэжлийн, 956 буюу 6.7 хувь нь дээд боловсролтой байна.

Харин 45-64 насны нийт 10190 малчдын 175 буюу 1.7 хувь нь боловсролгүй, 2121 буюу 20.7 хувь нь бага, 49.6 хувь нь суурь, 2101 буюу 20.5 хувь нь бүрэн дунд, 287 буюу 2.7 хувь нь техник болон тусгай мэргэжлийн, 487 буюу 4.8 хувь нь дээд боловсролтой байна.

III.5 МАЛЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭМД-ЫН ХАМРАГДАЛТ


2021 оны мал тооллогын дүнгээр, нийт малчдын 40.3 хувь нь буюу 11396 малчин нийгмийн даатгалд, 66.7 хувь нь буюу 18851 малчин эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна. Нийгмийн даатгал төлдөг малчдын 55.9 хувь нь эрэгтэй малчин, 44.1 хувь нь эмэгтэй малчин байна.

ЗУРАГ 3.5.1. НИЙГМИЙН ДААТГАЛД ХАМРАГДДАГ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, хүйсээр



Насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 3.6 хувь нь буюу 407 малчин, 25-34 насны малчдын 16.8 хувь нь буюу 1910 малчин, 35-44 насны малчдын 29.1 хувь нь буюу 3314 малчин, 45-54 насны малчдын 30.3 хувь нь буюу 3453 малчин, 55-64 насны малчдын 13.7 хувь нь буюу 1559 малчин, 65-аас дээш насны малчдын 6.6 хувь нь буюу 753 малчин нийгмийн даатгалд хамрагдсан байна.

ЗУРАГ 3.5.1. НИЙГМИЙН ДААТГАЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛД ХАМРАГДДАГ МАЛЧДЫН ЭЗЛЭХ ХУВЬ НАСНЫ БҮЛГЭЭР




III.6 ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ

2020 онд 26788 малчин гар утас, 5730 малчин интернэт хэрэглэдэг байсан бол 2021 оны байдлаар нийт малчдын 96.5 хувь нь буюу 27267 малчин гар утас хэрэглэж байгаа нь өмнөх оноос 489-өөр өссөн бол нийт малчдын 36.3 хувь нь буюу 10266 малчин интернэт хэрэглэж байгаа нь өмнөх оноос 4536-аар өссөн байна.

ХҮСНЭГТ 3.6.1 МАЛЧДЫН ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, насны бүлгээр

Насны бүлэг	Гар утас		2020/2019	Интернэт		2020/2019
	2020	2021		2020	2021	
Дүн	26778	27267	101.8	5730	10266	179.2
15-24	2231	2028	90.9	857	1242	144.9
25-34	5986	5798	96.9	1887	3024	160.3
35-44	7675	7811	101.8	1634	3180	194.6
45-54	6053	6367	105.2	943	1920	203.6
55-64	3158	3431	108.6	312	649	208.0
65+	1675	1832	109.4	97	251	258.8

ЗУРАГ 3.6.1. МАЛЧДЫН ГАР УТАС БОЛОН ИНТЕРНЭТ ХЭРЭГЛЭЭ, НАСНЫ БҮЛГЭЭР, 2021 ОН



Насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 97.4 хувь нь буюу 2028 малчин, 25-34 насны малчдын 97.6 хувь нь буюу 5798 малчин, 35-44 насны малчдын 97.6 хувь нь буюу 7811 малчин, 45-54 насны малчдын 96.5 хувь нь буюу 6367 малчин, 55-64 насны малчдын 95.5 хувь нь буюу 3431 малчин, 65-аас дээш насны малчдын 89.8 хувь нь буюу 1832 малчин гар утастай байна.

III.7 ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД

Нийт малчдын 36.4 хувь нь буюу 10297 малчин 2021 оны байдлаар зээлтэй байгаа ба 2020 онтой харьцуулахад 933 малчнаар өссөн байна. Зээлтэй малчдын тоог насны бүлгээр нь өмнөх онтой харьцуулбал 15-24, 25-34, 35-44, 45-54, 55-64 насны бүлэгт харгалзан 15, 186, 402, 270, 75 малчнаар тус тус өссөн, 65 ба түүнээс дээш насны бүлэгт 15 малчнаар буурсан байна.


ХҮСНЭГТ 3.7.ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, хувиар, насны бүлгээр

Насны бүлэг	Нийт малчид	Зээлтэй малчид		Зээлтэй малчдын нийт малчдад эзлэх хувь	Зээлтэй малчдын насны бүтэц, хувиар
		2020	2021		
Дүн	28257	9364	10297	36.4	100.0
15-24	2082	378	393	18.9	3.8
25-34	5939	2036	2222	37.4	21.6
35-44	8005	3036	3438	42.9	33.4
45-54	6599	2381	2651	40.2	25.7
55-64	3591	1121	1196	33.3	11.6
65+	2041	412	397	19.5	3.9

Зээлтэй малчдыг насны бүлгээр авч үзвэл, 15-24 насны малчдын 18.9 хувь нь буюу 393 малчин, 25-34 насны малчдын 37.5 хувь нь буюу 2222 малчин, 35-44 насны малчдын 42.9 хувь нь буюу 3438 малчин, 45-54 насны малчдын 40.2 хувь нь буюу 2651 малчин, 55-64 насны малчдын 33.3 хувь нь буюу 1196 малчин, 65- аас дээш насны малчдын 19.5 хувь нь буюу 397 малчин зээлтэй байна.

Зээлтэй малчдын 80.7 хувь буюу ихэнх хувийг 25-54 насны малчид эзэлж байна. Тухайлбал, 33.4 хувь нь 35-44 насных, 25.7 хувь нь 45-54 насных, 21.6 хувь нь 25-34 насны насны малчид байна.

ЗУРАГ 3.7.1 ЗЭЭЛТЭЙ МАЛЧИД, хувиар, насны бүлгээр



БҮЛЭГ 4

IV.1 МАЛЫН ТОО

Мал тооллогын 2021 оны жилийн эцсийн дүнгээр малын тоо 4022.7 мянгад хүрч, өмнөх оноос 456.4 мянга буюу 10.2 хувиар буурсан бөгөөд малын төрлөөр задлалал 270.0 мянган адуу, 240.0 үхэр, 19.0 мянган тэмээ, 2001.0 мянган хонь, 1493.6 мянган ямаа тоологдлоо.


Өмнөх онтой харьцуулахад хонь 114.1 мянган толгой буюу 5 хувь, ямаа 312.0 мянган толгой буюу 17 хувь, үхэр 12.1 мянган толгой буюу 5 хувь, адуу 10.6 мянган толгой буюу 4 хувь, тэмээ 7.5 мянган толгойгоор тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 4.1. МАЛЫН ТОО, төрлөөр, мянган толгой


Он	Дүн	Төрөл				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1930	2321.6	77.6	188.1	120.5	1668.8	266.6
1945	1581.4	67.2	152.9	110	1015.8	235.5
1950	1787.2	83.8	185.2	118.7	1037.1	362.4
1960	1723.5	72.4	226	131	922	372.1
1970	1707.6	39.1	223	167.7	992.8	285
1980	1933.4	35.4	183	199	1176.6	339.4
1990	2061.3	31.4	196	200.5	1219.9	413.5
2000	2159	16.5	178.1	174.8	1059	730.6
2010	2010.5	14.7	113.8	76.2	896.6	909.2
2011	2425.6	15.9	141.1	90.5	1051.7	1126.4
2012	2970.6	18.1	170.5	113.9	1310.9	1357.2
2013	3486	19.7	205.9	144.9	1541.3	1574.2
2014	4111.5	21.9	246.9	183.3	1821.1	1838.3
2015	4511	23.1	280.2	217.6	2021.8	1968.3
2016	5208.6	26.3	323.4	259.9	2378.5	2220.5
2017	5743.5	28.7	364	298.2	2663.3	2389.3
2018	5461.3	31.5	323.6	272.3	2588.1	2245.8
2019	5625.4	32.7	348.9	292.4	2606.8	2344.6
2020	4479.1	26.6	280.1	251.8	2115	1805.6
2021	4022.7	19.0	269.6	239.7	2000.9	1493.5

Нийт 95563 сарлаг 2021 онд тоологдсон нь нийт үхэр сүргийн 39.9 хувийг эзэлж байна. Сарлагийн тоо өмнөх оноос 5.9 хувь буюу 6.0 мянган толгойгоор буурсан байна.

ЗУРАГ 4.1.1 НИЙТ САРЛАГЫН ТОО, толгой




IV.1.1 МАЛЫН ТООГООР 2021 ОНД ТЭРГҮҮЛСЭН СУМ



Малын тоо Бат-Өлзий суманд 1.4 мянган толгой малаар өсөж, бусад 18 суманд буурсан дүнтэй гарлаа. Богд суманд хамгийн өндөр 82.9 мянган толгой буюу 26.4 хувиар буурсан байна. Гучин-Ус сум 48.9 мянган толгой буюу 31.1 хувь, Баян-Өндөр сум 40.3 толгой буюу 12.9 хувиар буурсан байна.

Аймгийн хэмжээнд Бүрд сум 292.4 мянган толгой малаар тэргүүлж, Баянгол сум 291.1 мянган толгой малаар удаалж, Хархорин сум 283.6 мянган толгой малаар гуравдугаарт, Баян-Өндөр сум 275.5 мянган толгой малаар дөрөвдүгээрт, Богд сум 270.6 мянган толгой малаар тавдугаарт орсон байна. Таван төрлөөр мал тус бүрийн дүнгээр 6.6 мянган толгой тэмээгээр Богд сум, 32.7 мянган толгой адуугаар Бат-Өлзий, 52.3 мянган толгой үхрээр Бат-Өлзий сум, 182.5 мянган толгой хониор Бүрд сум, 155.8 мянган толгой ямаагаар Богд сум тус тус тэргүүлж байна.

ЗУРАГ 4.1.1. МАЛЫН ТООГООР 2021 ОНД ТЭРГҮҮЛСЭН СУМ, малын төрлөөр



IV.2 ӨРХИЙН АЖ АХУЙН БОЛОН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН МАЛЫН ТОО

Аймгийн хэмжээнд 2021 онд тоологдсон 4022.7 мянган толгой малын 99.9 хувь буюу 4019.6 мянган мал нь өрхийн аж ахуйн мал, 0.1 хувь нь буюу 3058 мал нь аж ахуйн нэгж, байгууллагынх байна.

Өрхийн аж ахуйн буюу хувийн малын тоо 2021 онд 4019.6 мянган толгой болж өмнөх оныхоос 456.1 мянган толгой буюу 10.2 хувиар буурлаа. Адууны 99.96, үхрийн 99.89, тэмээний 99.89, хонины 99.89, ямааны 99.97 хувь нь өрхийн аж ахуйд байна.

Өрхийн аж ахуйн нийт малын 49.7 хувийг хонь, 37.1 хувийг ямаа, 0.5 хувийг тэмээ, 6.7 хувийг адуу, 6.0 хувийг үхэр тус тус эзэлж байна.

ХҮСНЭГТ 4.2.1. ӨРХИЙН АЖ АХУЙН БУЮУ ХУВИЙН МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Дүн	5737.6	5456.6	5621.5	4475.7	4019.6
Адуу	363.9	323.5	348.8	280	269.5
Үхэр	297.9	271.8	292	251.5	239.7
Тэмээ	28.7	31.4	32.7	26.6	19.0
Хонь	2659	2584.9	2604.2	2112.6	2000.9
Ямаа	2388	2245	2343.8	1805	1493.5

Аж ахуйн нэгж, байгууллагын малын тоо 2021 онд 3058 толгой болж, өмнөх оныхоос 282 толгой буюу 8.4 хувиар буурчээ. Аж ахуйн нэгж, байгууллагын нийт мал 2021 оны байдлаар 3.3 хувийг адуу, 8.6 хувийг үхэр, 0.7 хувийг тэмээ, 73.5 хувийг хонь, 13.9 хувийг ямаа эзэлж байна.

IV.3 ХУВИЙН МАЛТАЙ ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Малтай 19811 өрхийг малын тоогоор бүлэглэвэл нийт малтай өрхийн 2.9 хувь буюу 580 нь 10 хүртэл малтай, 9.3 хувь буюу 1837 өрх 11-30 хүртэл малтай, 9.01 хувь буюу 1786 өрх 31-50 хүртэл малтай, 16.7 хувь буюу 3313 өрх нь 51-100 хүртэл малтай, 26.8 хувь буюу 5305 өрх 101-200 малтай, 27.4 хувь буюу 5431 өрх 201-500 малтай, 6.02 хувь буюу 1194 өрх 501-999 малтай, 1.7 хувь буюу 327 өрх 1000-1499 малтай, 0.2 хувь буюу 37 өрх 1500-2000 малтай, 0.1 хувь буюу 8 өрх 2000-аас дээш малтай байна.

ХҮСНЭГТ 4.3.1. МАЛТАЙ ӨРХИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, малын төрлөөр


Бүлэглэл Т	Малтай өрхийн тоо		Малын тоо, мянган толгой						
	2020	2021	2020	2021	Төрөл				
					Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	19813	19811	4475.7	4019.6	19.0	269.5	239.4	1998.6	1493.1
10 хүртэлх	433	580	2.9	4.1	0.0	0.4	1.6	0.9	1.1
11-с 30	1464	1837	31.8	39.8	0.1	2.5	5.4	15.3	16.5
31-50	1549	1786	64.2	73.6	0.2	4.5	7.5	31.0	30.4
51-100	3193	3313	240.2	247.7	0.8	18.0	24.6	107.8	96.5
101-200	5166	5305	763.1	774.3	2.1	55.6	57.1	350.7	308.7
201-500	6074	5431	1885.3	1666.3	7.0	107.2	91.7	804.9	655.5
501-999	1539	1194	1009.3	777.9	5.4	49.2	34.3	423.4	265.6
1000-1499	348	327	393.6	366.3	2.1	26.0	14.6	222.6	100.9
1500-2000	37	30	61.7	50.0	0.8	3.9	1.8	30.1	13.4
2000 <	10	8	23.6	19.7	0.5	2.2	0.7	11.9	4.4

Малтай өрхийн бүлэглэлт тус бүрийн нийт малтай өрхөд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 10 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 0.7 пунктээр өссөн, 11-30 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 1.9 пунктээр өссөн, 31-50 хүртэл малтай өрхийнх 1.21 пунктээр өссөн, 51-100 хүртэл малтай өрхийнх 0.6 пунктээр өссөн, 101-200 хүртэл малтай өрхийнх 0.7 пунктээр өссөн бол 201-500 хүртэл малтай өрхийнх 3.3 пунктээр, 501-999 хүртэл малтай өрхийнх 1.78 пунктээр, 1000-1499 хүртэл малтай өрхийнх 0.1 пунктээр тус тус буурсан, 1500-2000 хүртэлх малтай, 2001-с дээш малтай өрхийн хувьд хэвийн түвшинд байна.

ХҮСНЭГТ 4.3.2. МАЛТАЙ НЭГ ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО, малын тооны бүлэглэлтээр, малын төрлөөр

Бүлэглэлт	2020	2021	Төрөл				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дүн	226	203	1	14	12	101	75
10 хүртэлх	7	7	-	1	3	2	2
11-с 30	22	22	-	1	3	8	9
31-50	41	41	-	3	4	17	17
51-100	75	75	-	5	7	33	29
101-200	148	146	-	10	11	66	58
201-500	310	307	1	20	17	148	121
501-999	656	652	5	41	29	355	222
1000-1499	1131	1120	7	80	45	681	309
1500-2000	1669	1668	26	130	61	1003	447
2000 <	2359	2460	57	275	91	1485	553


ЗУРАГ 4.3.1. НЭГ МАЛЧИН ӨРХӨД НОГДОХ МАЛЫН ТОО



Малтай нэг өрхөд аймгийн дунджаар 203 толгой мал ногдож байгаа нь өмнөх онохоос 23 толгой малаар буурсан байна. Малтай нэг өрхөд дунджаар тэмээ 1, адуу 14, үхэр 12, хонь 101, ямаа 75 тус тус ногдож байна. Малтай нэг өрхөд ногдох малын 86.7 хувь нь бог мал, 13.3 хувь нь бод мал байна. Иргэдийг бүлэглэвэл 101-200 малтай нэг өрхөд дунджаар 146, 201-500 малтай нэг өрхөд 307, 501-999 малтай нэг өрхөд 652 толгой мал тус тус ногдож байна. 1000 ба түүнээс дээш малтай 365 өрх байгаа нь өмнөх онохоос 7.8 хувь буюу 30-аар буурсан байна. Бүрд сум 70 мянгат малчны тоогоор тэргүүлж, Баянгол сум 53 мянгат малчинтайгаар хоёрдугаарт, Баян-Өндөр сум 51 мянгат малчинтайгаар гуравдугаарт орж байна.

IV.4. СҮРГИЙН БҮТЭЦ

ЗУРАГ 4.4.1. БОГ МАЛД ХОНЬ, ЯМААНЫ ЭЗЛЭХ ХУВЬ



■ Бог малд ямааны эзлэх хувь
■ Бог малд хонины эзлэх хувь

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2021 оны байдлаар авч үзвэл, хонь 49.7 хувь, ямаа 37.1 хувь, үхэр 6.0 хувь, адуу 6.7, тэмээ 0.5 хувийг эзэлж байна. Хонин сүргийн эзлэх хувь 2021 онд өмнөх оноос 2.5 пункт, үхэр сүргийн эзлэх хувь 0.4 пунктээр, адуун сүргийн эзлэх хувь 0.4 пунктээр өсөж, ямаан сүргийн эзлэх хувь 3.2 пункт, тэмээн сүргийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус буурсан байна.

2021 оны байдлаар нийт мал сүргийн 86.8 хувийг бог мал, 13.2 хувийг бод мал эзэлж, нийт бод малд адуу давамгайлж байгаа ба 51.0 хувийг, үхэр 45.4 хувийг, тэмээ 3.6 хувийг эзэлж байна. Бог малд хонь давамгайлж 57.3 хувийг эзэлж байгаа бол ямаа 42.7 хувийг эзэлж байна.


ХҮСНЭГТ 4.4.1 СҮРГИЙН БҮТЭЦ, 2021 ОН, малын төрлөөр

	Бүгд	Төл, өсвөр насны мал	Нас гүйцсэн эр мал		Хээлтэгч	Хээлтүүлэгч
	мянган толгой					
Дүн	4022.7	872.7	1180		1933.8	36.3
Адуу	269.6	93.3	59.8		105.3	11.2
Үхэр	239.7	85.8	51.0		99.7	3.2
Тэмээ	19.0	5.6	5.4		7.8	0.2
Хонь	2000.9	454.3	567.0		967.7	11.9
Ямаа	1493.5	233.7	496.8		753.2	9.8
дүнд эзлэх хувь						
Дүн	100	21.7	29.3		48.1	0.9
Адуу	100	34.6	22.2		39.1	4.2
Үхэр	100	35.8	21.3		41.6	1.3
Тэмээ	100	29.5	28.4		41.1	1.1
Хонь	100	22.7	28.3		48.4	0.6
Ямаа	100	15.6	33.3		50.4	0.7


Сүргийн бүтцийг 2021 оны байдлаар авч үзвэл, нийт сүргийн 21.7 хувь буюу 872.7 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 29.3 хувь буюу 1180.0 мянган толгой нь ажлын ба бэлтгэлийн насны эр мал, 48.1 хувь буюу 1933.8 мянган толгой мал нь хээлтэгч мал, 0.9 хувь нь буюу 36.3 мянган толгой мал нь хээлтүүлэгч мал байна.

Малын нас, хүйсээр нийт сүрэгт эзлэх хувийн жинг 2020 оныхтой харьцуулж үзэхэд 2021 онд төл, өсвөр насны малын сүрэгт эзлэх хувь 2.2 пунктээр, нас гүйцсэн эр малын эзлэх хувь 1.6 пунктээр тус тус буурч, хээлтэгч малын эзлэх хувь 3.7 пункт, хээлтүүлэгч мал 0.1 пунктээр тус тус өссөн дүнтэй байна.

ЗУРАГ 4.4.2. НИЙТ МАЛД БОД, БОГ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



ЗУРАГ 4.4.2. НИЙТ МАЛД 5 ТӨРӨЛ ТУС БҮРИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



ХҮСНЭГТ 4.4.2 СҮРГИЙН БҮТЭЦ, хувиар

Малын төрөл		2015	2016	2017	2018	2019	2020	2021
Адуу								
Дүн		100	100	100	100	100	100	100
Төл, өсвөр насны		44.5	44.3	45.4	36.4	33.4	37.9	34.6
Нас гүйцсэн эр		22.9	22.6	21.4	26	30.3	22.3	22.2
Хээлтэгч		29.3	29.9	30.1	34.2	32.8	35.9	39
Хээлтүүлэгч		3.2	3.2	3.1	3.5	3.5	3.9	4.2
Үхэр								
Дүн		100	100	100	100	100	100	100
Төл, өсвөр насны		44.2	43.6	43.8	39.6	42.7	42.3	35.8
Нас гүйцсэн эр		19.6	20.1	21.4	21.4	19.1	19.2	21.3
Хээлтэгч		34.9	35	34.9	37.9	37.1	37.4	41.6
Хээлтүүлэгч		1.3	1.4	1.2	1.1	1.1	1.1	1.3
Тэмээ								
Дүн		100	100	100	100	100	100	100
Төл, өсвөр насны		41.8	42.1	41.3	42.6	24.9	42.7	29.4
Нас гүйцсэн эр		21	21.1	21.9	21.6	38.3	22.5	28.4
Хээлтэгч		36.2	35.5	35.8	34.8	35.9	33.9	41.1
Хээлтүүлэгч		1.1	1.1	1	1	1	0.9	1.1
Хонь								
Дүн		100	100	100	100	100	100	100
Төл, өсвөр насны		32.5	31.9	32	24.1	31	25	22.7
Нас гүйцсэн эр		24.9	25.6	25.9	30.7	26.3	29.2	28.3
Хээлтэгч		42	42	41.5	44.6	42.2	45.3	48.4
Хээлтүүлэгч		0.6	0.6	0.5	0.5	0.5	0.5	0.6
Ямаа								
Дүн		100	100	100	100	100	100	100
Төл, өсвөр насны		27.6	28.1	27.9	16.1	26.5	17.8	15.6
Нас гүйцсэн эр		31.2	31	31.5	38.6	32.1	36.1	33.3
Хээлтэгч		40.6	40.4	40	44.9	40.9	45.7	50.4
Хээлтүүлэгч		0.6	0.5	0.5	0.5	0.5	0.5	0.7

IV.5. ХЭЭЛТЭГЧ МАЛ


2021 оны эцэст нийт 1933.7 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 48.1 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 53.2 мянган толгой малаар буюу 2.7 хувиар буурсан байна. Хээлтэгч малыг таван төрлөөр нь авч үзвэл ингэ өмнөх оноос 1.1 мянган толгой малаар 12.2 хувиар, эм ямаа 71.2 мянган толгой малаар буюу 8.6 хувиар тус тус буурч, гүү 4.7 мянган толгой малаар буюу 4.7 хувиар, үнээ 5.6 мянган толгой малаар буюу 6 хувиар, эм хонь 8.8 мянган толгой малаар буюу 0.9 хувиар тус тус өссөн дүнтэй байна.

ХҮСНЭГТ 4.5.1 ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2020	2021/2020	
	мянган толгой					зөрүү	хувь
Дүн	2285.5	2387.5	2295.3	1986.9	1933.8	-53.1	97.3
Ингэ	10.3	10.9	11.7	9	7.9	-1.1	87.8
Гүү	109.4	110.5	114.6	100.6	105.3	4.7	104.7
Үнээ	104.3	103.1	108.6	94.1	99.7	5.6	106.0
Эм хонь	1105.2	1155	1100.6	958.9	967.7	8.8	100.9
Эм ямаа	956.4	1007.9	959.8	824.4	753.2	-71.2	91.4

Хээлтэгч мал нийт малын 48.1 хувийг эзэлж байгаа бөгөөд адуун сүргийн 39.0 хувь, тэмээн сүргийн 41.1 хувь, үхэр сүргийн 41.6 хувь, хонин сүргийн 48.4 хувь, ямаан сүргийн 50.4 хувийг тус тус эзэлж байна. Сүрэгт хээлтэгч малын эзлэх хувийн жин өмнөх оноос гүү 3.1 пункт, ингэ 7.2 пункт, үнээ 4.2 пункт, эм хонь 3.1 пункт, эм ямаа 4.7 пунктээр тус тус өссөн байна. 2021 оны байдлаар оны эхний төллөх эх малын 58.3 хувь буюу 1157.3 мянган эх мал төллөсөн байгаа нь өмнөх оноос 433.4 мянган хээлтэгчээр буурсан байна.

ЗУРАГ 4.5.1 ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО



IV.6. ТӨЛ БОЙЖИЛТ

Оны эхний төллөх эх малын 58.3 хувь буюу 1157.3 хувь мянган эх мал төллөж, гарсан төлийн 88.5 хувь буюу 1024.1 мянган төлийг бойжуулсан байна. Бойжсон төлийн тоо 2020 оноос 333.0 мянган толгойгоор буюу 24.5 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 5.6.1 ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	Гарсан төл, мянган толгой				
Дүн	1956.6	1657.7	2158.7	1590.7	1157.3
Ботго	4.9	5.2	5.8	5.6	2.2
Унага	89.8	58	96.8	66.3	55
Тугал	85.6	75.8	91.9	80	57.4
Хурга	944.8	865.2	1062	827.6	630.1
Ишиг	831.5	653.5	902.2	611.2	412.6
Бойжсон төл, мянган толгой					
Дүн	1890.5	1338.7	2000.6	1357.1	1024.1
Ботго	4.9	5.1	5.7	4.7	1.8
Унага	89	46.9	91.8	54.8	48.2
Тугал	84.8	64.9	87.9	74.4	52.5
Хурга	925.2	740.8	994.5	726.1	570.1
Ишиг	786.6	481	820.7	497.1	351.5
Төл бойжилтын хувь					
Дүн	96.6	80.8	92.7	85.3	88.5
Ботго	98.9	98.1	51.8	84	82.0
Унага	99.1	80.9	83	82.7	87.8
Тугал	99.1	85.6	85.3	93	91.4
Хурга	97.9	85.6	86.1	87.7	90.5
Ишиг	94.6	73.6	81.4	81.3	85.2
100 эхээс бойжуулсан төл, хувь					
Дүн	90.3	56.1	83.8	59.1	51.5
Ботго	53	46.5	51.8	40	19.7
Унага	92	42.5	83	47.9	48.0
Тугал	93.2	62.9	85.3	68.5	55.8
Хурга	92.7	64.1	86.1	66	59.5
Ишиг	90.6	47.7	81.4	51.8	42.6

Гарсан ботгоны 82.0 хувь, унаганы 87.8 хувь, тугалны 91.4 хувь, хурганы 90.5 хувь, ишигний 85.2 хувийг бойжуулсан байна. Өмнөх оныхтой харьцуулахад, бойжуулсан ботго 2.9 мянган толгойгоор, унага 6.6 мянган толгойгоор, тугал 21.9 мянган толгойгоор, хурга 156.0 мянган толгойгоор, ишиг 145.6 мянган толгойгоор тус тус буурсан байна.

2021 онд 100 эхээс дунджаар 52 төл бойжуулсан нь өмнөх оноос 7 толгой төлөөр бага байна. Үүнээс ботго 20, тугал 13, хурга 6, ишиг 9 толгойгоор тус тус бага бойжуулсан бол унага өмнөх онтой адил төл бойжсон байна.

ЗУРАГ 5.6.1 БОЙЖСОН ТӨЛ, оноор



IV.7 ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ

Эх мал хээл хаяж сувайрах нь арчилгаа маллагаа, байгаль цаг уурын байдал, хээлтэгч хээлтүүлэгчийн тохиргоо болон хээлтүүлэг хийгээгүй зэргээс шалтгаалдаг.

2021 онд оны эхний хээлтэгч малын 4.3 хувьтай тэнцэх 86.3 мянган мал хээл хаяж, 37.5 хувьтай тэнцэх 745.3 мянган мал сувайрсан байна. Хээл хаясан хээлтэгч малын тоо 2020 оныхоос 1.7 мянган толгойгоор буурч, сувайрсан хээлтэгч малын тоо 245.3 мянган толгойгоор өсжээ.

ХҮСНЭГТ 4.7.1 ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛЫН ТОО


Төрөл	Сувайрсан мал					Хээл хаясан мал				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой									
Дүн	144.5	451.3	262.1	546.9	745.3	24.9	152.9	54.6	137.9	86.3
Ингэ	0.1	0.2	0.2	0.5	1.9	0.04	0.01	0.002	0.03	0.07
Гүү	9	32.6	17.4	35.1	40.2	0.9	14.2	2.2	10.1	6.3
Үнээ	7.5	22.7	14.6	22.6	34.0	0.7	4.5	1.5	4.1	2.8
Эм хонь	63.1	196.7	121.7	236	315.2	6.9	36.5	15.9	34.4	21.2
Эм ямаа	64.7	198.9	108.2	252.6	354.0	16.4	97.8	35	89.3	55.9

2021 онд оны эхний хээлтэгч малын 41.8 хувь нь хээл хаяж, сувайржээ. Энэ үзүүлэлт 2020 оныхоос 11.8 пунктээр өссөн байна. Оны эхний хээлтэгч малд ингэний 21.9 хувь, гүүний 46.3 хувь, үнээний 24.7 хувь, эм хонины 35.1 хувь, эм ямааны 49.7 хувь нь хээл хаяж, сувайрсан байна.

ХҮСНЭГТ 4.7.2 ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТООНД ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Төрөл	Сувайрсан мал					Хээл хаясан мал				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	хувь									
Дүн	6.3	18.9	4.7	23.8	37.5	1.1	6.4	1.1	6	4.3
Ингэ	0.7	2.1	0.5	4.6	21.1	0.4	0.1	0.01	0.2	0.8
Гүү	8.3	29.5	5	30.7	40.0	0.9	12.8	0.6	8.8	6.3
Үнээ	7.2	22.1	5	20.9	36.1	0.6	4.4	0.5	3.8	3.0
Эм хонь	5.7	17	4.7	21.4	32.9	0.6	3.2	0.6	3.1	2.2
Эм ямаа	6.8	19.7	4.6	26.3	42.9	1.7	9.7	1.5	9.3	6.8

ЗУРАГ 4.7.1 ОНЫ ЭХНИЙ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТООНД ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН, МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ



IV.8 ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО

Хээлтүүлэгч мал 2021 онд 36295 тоологдож өмнөх оноос 1673 толгойгоор буюу 4.8 хувиар өсжээ.

ХҮСНЭГТ 4.8.1 ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	Хээлтүүлэгч мал					Үүнээс: шинээр тавьсан				
	2017	2018	2019	2020	2021	2017	2018	2019	2020	2021
	толгой									
Дүн	41281	37641	40153	34622	36295	32	22	33	20	10
Буур	301	321	319	240	234	-	3	1	-	-
Азарга	11447	11322	12115	10816	11140	22	8	15	13	8
Бух	3612	2928	3292	2849	3218	8	2	3	3	1
Хуц	14073	12704	13148	11110	11869	1	3	7	2	1
Ухна	11848	10366	11279	9607	9834	1	6	7	2	-

Үржлийн нормоор нэг буурт 20-25 ингэ, нэг азарганд 12-25 гүү, нэг бухад 35-45 үнээ, нэг хуцанд 25-30 эм хонь, нэг ухнад 25-30 эм ямаа ногддог.

Сүүлийн жилүүдэд хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдаж, бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд үржлийн норм алдагдсанаас, эх малын сувайралт гарахад нөлөөлж байна.

ХҮСНЭГТ 4.8.2 ХЭЭЛТЭГЧ, ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТОХИРОО, малын төрлөөр

Төрөл	Үржлийн норм	2016	2017	2018	2019	2020	2021
Ингэ	20-25	32	34	34	37	37	34
Гүү	12-25	9	10	10	9	9	9
Үнээ	35-45	26	29	35	33	33	31
Эм хонь	25-30	75	78	91	84	86	82
Эм ямаа	25-30	78	81	97	85	85	77

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад 2021 онд аймгийн дунджаар 1 хуцанд 82 эм хонь, 1 ухнад 77 эм ямаа, 1 азарганд 9 гүү, 1 бууранд 34 ингэ, 1 буханд 31 үнээ ногдож байгаа нь бог малын норм 2.5-2.6 дахин хэтэрч, хээлтэгч хээлтүүлэгчийн тохиргоо алдагдсан хэвээр байна.

IV.9 МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Оны эхний нийт малын 28.6 хувьтай тэнцэх 1283.5 мянган малыг 2021 онд хэрэглээнд зарцуулж, 19.6 хувь буюу 877.8 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулж, 7.3 хувь буюу 327.1 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэж, 1.8 хувь буюу 78.6 мянган толгой малыг бусдад шилжүүлсэн байна.

Малын хэрэглээний зарлага өмнөх оныхоос 1009.6 мянган толгой буюу 44.2 хувиар буурсан байна. Малын зарлагыг төрлөөр авч үзвэл, адууны зарлага өмнөх оныхоос 52.3 мянган толгой буюу 44.9 хувь, тэмээнийх 4.4 мянган толгой буюу 45.7 хувь, хониных 452.3 мянган толгой буюу 42.3 хувь, ямааных 368.5 мянган толгой буюу 41.0 хувиар, үхрийнх 46.7 мянган толгой буюу 40.6 хувиар тус тус буурчээ. Малтай нэг өрх 2020 онд дунджаар 115 толгой малыг өөрийн болон бусдын хэрэглээнд зориулан зарцуулж байсан бол 2021 онд 65 толгой мал зарцуулжээ. Хэрэглээнд зарцуулсан малын 89.3 хувийг бог мал, 10.7 хувийг бод мал эзэлж байгаа бөгөөд оны эхэнд байсан тэмээний 15.8 хувь, адууны 18.3 хувь, үхрийн 23.4 хувь, хонины 23.6 хувь, ямааны 22.6 хувийг хэрэглээнд зарцуулжээ.

ХҮСНЭГТ 4.9.1 МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, талын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Дүн	1326.2	1268.6	1732.9	2293.1	1283.5
Тэмээ	2.4	2.2	4.4	9.7	5.2
Адуу	47.5	54.5	62.5	111.3	64
Үхэр	45.7	61.3	64	105.7	68.3
Хонь	629.4	675.7	932.9	1127.1	616
Ямаа	601.2	474.9	669.2	939.2	530

Оны эхний малд эзлэх хувь

Дүн	25.5	22.1	31.7	40.8	28.7
Тэмээ	9.1	7.6	13.9	29.7	19.5
Адуу	14.7	15	19.3	31.9	22.9
Үхэр	17.6	20.5	23.5	36.1	27.1
Хонь	26.5	25.4	36	43.2	29.1
Ямаа	27.1	19.9	29.8	40.1	29.4


IV.10 ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ

2021 онд 327.1 мянган толгой мал хүнсэнд хэрэглэж өмнөх оноос 71.6 мянган толгой малаар бага байна. Малтай нэг өрх дунджаар 17 толгой мал хүнсэндээ хэрэглэсэн байна. Нийт хүнсэнд хэрэглэсэн малын 92.9 хувийг бог мал эзэлж байна.


ХҮСНЭГТ 4.10.1 ХҮНСЭНД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	Хүнсэнд хэрэглэсэн				
	2017	2018	2019	2020	2021
	мянган толгой				
Дүн	341.2	324.1	366.5	398.7	327.1
Тэмээ	0.5	0.6	0.6	0.8	0.7
Адуу	9.3	9.3	9.8	11.1	9.2
Үхэр	11.5	13.7	13.2	15	13.1
Хонь	160.7	162.3	186.4	200.7	161.1
Ямаа	159.2	138.2	156.6	171	143

ЗУРАГ 4.10.1 ХҮНСЭНД ХЭРЭГЛЭСЭН МАЛЫН ТОО



ЗУРАГ 4.10.2 МАЛТАЙ НЭГ ӨРХИЙН ДУНДАЖ ХҮНСНИЙ ХЭРЭГЛЭЭ



IV.11 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

2021 онд оны эхний нийт малын 7.3 хувь буюу 328.7 мянган толгой мал хорогдсон нь өмнөх оныхоос 118.3 мянган толгой өмнөх оны нийт хорогдлоос 56.2 хувиар өссөн байна. Нийт хорогдсон малын 47.9 хувийг ямаа, 39.7 хувийг хонь, 6.6 хувийг адуу, 4.4 хувийг үхэр, 1.5 хувийг тэмээний хорогдол эзэлж байна. Хорогдлын 87.6 хувийг бог мал эзэлж байна.


Нийт хорогдсон малыг шалтгаанаар нь авч үзвэл 6.2 хувь буюу 20.3 мянга нь цас, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюулаар, 0.7 хувь буюу 2.2 мянга нь өвчнөөр, 0.5 хувь буюу 1.7 мянга нь зэрлэг амьтанд бариулсанаар, 92.6 хувь буюу 304.5 мянга нь малын хариулга, арчилгаа маллагаатай холбоотой бусад шалтгааны улмаас хорогджээ.

ХҮСНЭГТ 4.11.1 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, малын төрлөөр


Төрөл	2017	2018	2019	2020	2021
Малын зүй бус хорогдол, мянган толгой					
Дүн	29.3	352.3	103.6	210.4	328.7
Тэмээ	0.1	0.2	0.1	1.1	1.5
Адуу	0.8	32.9	4	12.3	4.4
Үхэр	0.9	29.5	3.8	9.3	6.6
Хонь	10.9	140.3	42.9	90.8	39.7
Ямаа	16.6	149.4	52.7	96.9	47.9
Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь					
Дүн	0.6	6.5	1.8	3.7	7.3
Тэмээ	0.2	0.6	0.4	3.4	2.7
Адуу	0.3	10.2	1.2	3.5	3.3
Үхэр	0.3	10.8	1.3	3.2	5.2
Хонь	0.5	5.4	1.6	3.5	7.6
Ямаа	0.7	6.7	2.2	4.1	7.9
Зүй бусаар хорогдсон нийт малд эзлэх хувь					
Дүн	100	100	100	100	100
Тэмээ	0.2	0.1	0.1	0.5	1.5
Адуу	2.9	9.3	3.9	5.9	4.4
Үхэр	2.9	8.4	3.7	4.4	6.6
Хонь	37.3	39.8	41.4	43.2	39.7
Ямаа	56.7	42.4	50.9	46	47.9

2021 онд гарсан нийт хорогдлын 53.6 хувь нь Богд, Гучин-Ус, Баруунбаян-Улаан сумдад гарчээ. Богд суманд оны эхний малын 18.0 хувь, Баруунбаян-Улаан суманд 15.8 хувь, Гучин-Ус суманд 19.8 хувь нь хорогдсон байна.

ЗУРАГ 4.11.1 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ




ЗУРАГ 4.11.2 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, СУМДЫН ЭЗЛЭХ ХУВЬ



Манай аймагт хамгийн их хэмжээгээр том малын зүй бус хорогдол гарсан жил нь 2010 он бөгөөд оны эхний малын 46.0 хувь буюу 1664.3 мянган толгой мал зүй бусаар хорогдож байжээ.

ЗУРАГ 4.11.3 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ ОНЫ ЭХНИЙ МАЛД ЭЗЛЭХ ХУВЬ



2021 онд гэнэтийн аюул, аюулт үзэгдлээр хорогдсон малын 92.4 хувь нь бог мал байна. Гэнэтийн аюулаар хорогдсон малд эзлэх хувийн жин 2020 оныхоос хонь 4.1 пунктээр, тэмээ 2.2 пунктээр өссөн бол ямаа 3.6 пунктээр, адуу 1.7 пунктээр, үхэр 1.7 пунктээр тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 4.11.2 ГЭНЭТИЙН АЮУЛ, АЮУЛТ ҮЗЭГДЛЭЭР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, малын төрлөөр

Төрөл	2017	2018	2019	2020	2021
	толгой				
Дүн	4974	12866	17901	18898	20347
Тэмээ	7	15	37	146	605
Адуу	292	240	510	837	558
Үхэр	177	365	506	681	389
Хонь	2057	5108	6811	7345	8962
Ямаа	2441	7138	10037	9809	9833


IV.ТЭЖЭЭВЭР АМЬТАД

Аймгийн хэмжээнд 229 гахай, 169 шувуу, 45 бүл зөгий тоологдсон нь өмнөх оноос зөгий 38.4 хувиар, шувуу 15.1 хувиар тус тус буурсан бол гахай 25.8 хувиар өссөн байна. Зөгийн бүл 45 тоологдсон нь Хархорин суманд 30, Хужирт суманд 15 бүл байна. Тэжээвэр амьтдын дотор гахай, шувууны аж ахуйг илүүтэй эрхэлж байна.

ХҮСНЭГТ 4.12.1 ГЭНЭТИЙН АЮУЛ, АЮУЛТ ҮЗЭГДЛЭЭР ХОРОГДСОН МАЛЫН ТОО, малын төрлөөр

төрөл	2017	2018	2019	2020	2021	2020/2021	
						Зөрүү	Өсөлтийн хувь
Гахай, мянган толгой	281	219	123	182	229	47	25.8
Шувуу, мянган толгой	549	462	150	199	169	-30	-15.1
Зөгий, бүл	152	52	74	73	45	-28	-38.4


ЗУРАГ 4.12.1 ТЭЖЭЭВЭР АМЬТАД




Инфографик
infographic




НИЙТ ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га




ХУРААСАН УРГАЦ, тн



Үр тариа / Cereals



Төмс / Potatoes



Хүнсний ногоо /
Vegetables



Бэлтгэсэн өвс /
Hay harvest

БҮЛЭГ 5

V.1 ТАРИАЛСАН ТАЛБАЙ

Аймгийн хэмжээнд 8520.2 га-д үр тариа тариалсан ба үүний 8300 га-д буудай, 18.2 га-д арвай, 302 га-д овъёос тариалсан ба үр тариа тариалалт өмнөх оноос 2922.4 га-р их хийгдсэн байна. Хаврын тариалалтаар 420.1 га-д төмс, 270.2 га-д хүнсний ногоо тариалсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төмс 6.9 га-гаар, хүнсний ногоо 12.8 га-гаар их тариалсан байна. Ногоон тэжээл 5665.6 га-д, рапс 1103 га-д тариалсан байна. Хархорин суманд 1103 га-д рапс тариалсан байна.

ХҮСНЭГТ V.1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	Зөрүү	Хувь
	га							
Нийт тариалсан талбай	7260.2	9477.9	7716.2	8729.1	8719.6	14878.4	6158.8	170.6
Үр тариа	5703.7	8217.5	5893.5	7132.6	5597.8	8520.2	2922.4	152.2
Төмс	375.1	395.1	373	391.8	413.2	420.1	6.9	101.7
Хүнсний ногоо	205.9	213.6	210.9	232.2	257.4	270.2	12.8	105.0
Тэжээлийн ургамал	975.5	651.7	1238.8	972.5	2451.2	5667.9	3216.7	231.2

V.2 ХУРААСАН УРГАЦ

Өвөрхангай аймаг 2021 онд 15761.8 тонн үр тариа, 4163.2 тонн төмс, 2771.7 тонн хүнсний ногоо, 12707.5 тн гар тэжээл, 745 тн рапс хураасан нь 2020 оныхоос үр тариа 12.2 мянган тонноор буюу 4.3 дахин, хүнсний ногоо 186.3 тонноор буюу 86.3 хувиар, тэжээлийн ургамал 9.4 мянган тонноор буюу 2.7 дахин илүү ургац хураан авсан байна. Харин төмс өмнөх оноос 61.3 тонноор бага ургац хураан авсан байна. 2021 онд хураасан үр тарианы 97.8 хувь нь буюу 15410 тонн улаан буудай, 2.0 хувь буюу 315 тонн нь овъёос, 0.2 хувь буюу 36.8 тонн нь арвай байна.

ХҮСНЭГТ V.1. ТАРИАЛСАН ТАЛБАЙ

Төрөл	2016	2017	2018	2019	2020	2021	Зөрүү	Хувь
	тонн							
Үр тариа	8228	2113	5214	6358.5	3563.5	15761.8	12198.3	442.3123
Төмс	4221.9	3917.6	4152.6	4419.1	4224.5	4163.2	-61.3	98.54894
Хүнсний ногоо	2672.6	2020	2134.5	2540.2	2585.4	2771.7	186.3	107.2058
Тэжээлийн ургамал	2485.3	1506.3	3520.3	2331.3	5376.8	14777.7	9400.9	274.8419

ДУГНЭЛТ

2021 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 4022.7 мянган толгойд хүрч, өмнөх оноос 456.4 мянган толгойгоор буурсан ба төрлөөр авч үзвэл тэмээ 19.0 мянга, адуу 269.6 мянга, үхэр 239.7 мянга, хонь 2000.9 мянга, ямаа 1493.5 мянга болж, тэмээ 28.3 хувь буюу 7.5 мянган толгойгоор, адуу 3.8 хувь буюу 10.6 мянган толгой, үхэр 4.8 хувь буюу 12.1 мянган толгой, хонь 5.4 хувь буюу 114.1 мянган толгой, ямаа 17.3 хувь буюу 312.1 мянган толгойгоор тус тус буурсан байна.

Нийт мал сүргийн дотор тэмээ 0.5 хувь, адуу 6.7 хувь, үхэр 6.0 хувь, хонь 49.7 хувь, ямаа 37.1 хувийг тус тус эзэлж, нийт сүрэгт 5 төрлийн малын эзлэх хувь өмнөх оныхоос адуун сүргийн эзлэх хувь 0.4 пунктээр, үхэр сүргийн эзлэх хувь 0.4 пунктээр, хонин сүргийн хувьд 2.5 пунктээр өсч, ямаан сүргийн эзлэх хувь 3.2 пунктээр, тэмээн сүргийн эзлэх хувь 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Малын тоо 18 суманд буурч Бат-Өлзий суманд өссөн дүнтэй гарлаа. Гучин-Ус суманд хамгийн өндөр 31.3 хувь буюу 48.9 мянган толгойгоор буурсан байна. Богд суманд 26.4 хувиар, Баруунбаян-Улаан суманд 21.5 хувиар буурсан бөгөөд Арвайхээр суманд хамгийн бага буюу 4.4 хувиар буурсан дүнтэй байна. Бат-Өлзий сум 0.5 хувиар буюу 1.3 мянган толгой малаар өссөн дүнтэй байна.

Малтай өрх 19811 байгаа ба үүний 90.0 хувь буюу 17838 нь малчин өрх байна. Эдгээр өрхийн тоо 2020 оныхоос малтай өрх 0.01 хувиар буюу 2 өрхөөр буурч, малчин өрх 2.1 хувиар буюу 374 өрхөөр нэмэгдсэн байна. Малчдын тоо 28257 болж өмнөх оноос 0.26 хувиар буюу 76-аар буурсан байна. Нийт малчдын 28.4 хувь нь 15-34 насны, 56.04 хувь нь 35-59 насны, 15.6 хувь нь 60 болон түүнээс дээш насны малчид байна. Аймгийн малтай нэг өрхөд 203 толгой мал, нэг малчин өрхөд 226 толгой мал ноогдож байна.

Аймгийн хэмжээнд Бүрд сум 292.4 мянган толгой малаар тэргүүлж, Баянгол сум 291.1 мянган толгойгоор удаалж, Хархорин сум 283.6 мянган толгой малаар гуравдугаарт, Баян-Өндөр сум 275.5 мянган толгой малаар дөрөвдүгээрт, Уянга сум 270.6 мянган толгой малаар тавдугаарт орж байна. Таван төрлийн мал тус бүрийн дүнгээр 6.6 мянган толгой тэмээгээр Богд, 32.7 мянган толгой адуугаар Бат-Өлзий, 52.3 мянган толгой үхрээр Бат-Өлзий, 182.5 мянган толгой хониор Бүрд, 155.8 мянган толгой ямаагаар Богд сум тус тус тэргүүлж байна.

Аймгийн 112 баг дотор нийт малын тоогоор Баянгол сумын Өндөр-Өнц баг 86.2 мянган толгой малаар нэгдүгээрт, Бүрд сумын Аржаргалант баг 68.3 мянган толгой малаар хоёрдугаарт, Бат-Өлзий сумын Зөрүүлэг баг 71.4 мянган толгой малаар гуравдугаарт, Бүрд сумын Донгит баг 70.4 мянган толгой малаар дөрөвдүгээрт, Баянгол сумын Цавын-Ихэр баг 68.3 мянган толгой малаар тавдугаарт тус тус орж байна. Төрөл тус бүрээр 3.2 мянган толгой тэмээгээр Богд сумын Далан, 9.5 мянган толгой адуугаар Бат-Өлзий сумын Зөрүүлэг баг, 15.4 мянган толгой үхрээр Бат-өлзий сумын Улиастай баг, 54.2 мянган толгой хониор Бүрд сумын Ар жаргалант баг, 31.9 мянган толгой ямаагаар Баянгол сумын Өндөр-Өнц багууд тус тус тэргүүлж байна.

Аймгийн хэмжээнд нийт малаараа Бүрд сумын Их боригдой багийн малчин өрх 2975 толгой мал тоолуулж аймагтаа тэргүүлсэн байна. Хамгийн олон тэмээтэй өрх Гучин-Ус сумын 4-р багт, хамгийн олон адуутай өрх Бүрд сумын Ар жаргалант багт, хамгийн олон үхэртэй өрх Бат-Өлзий сумын Улиастай багт, хамгийн олон хоньтой өрх Бүрд сумын Их боригдой багт, хамгийн олон ямаатай өрх Төгрөг сумын Мазар багт байна.

1000 ба түүнээс дээш малтай 365 өрх байгаа нь өмнөх оныхоос 7.6 хувь буюу 30-аар буурсан дүнтэй байна. Хамгийн олон мянгат малчинтай сумдаар Бүрд сум 70 мянгат малчин, Баянгол сум 53 мянгат малчин, Баян-Өндөр сум 50 мянгат малчинтай байна. Аймгийн хэмжээнд 2001-ээс дээш мал тоолуулсан 8 өрх байгаагийн 62.5 хувь нь Бүрд, 25 хувь нь Баянгол, 12.5 хувь нь Сант суманд байна.

Нийт малтай өрхийн 2.9 хувь буюу 580 нь 10 хүртэл малтай, 9.3 хувь буюу 1837 өрх 11-30 хүртэл малтай, 9.01 хувь буюу 1786 өрх 31-50 хүртэл малтай, 16.7 хувь буюу 3313 өрх нь 51-100 хүртэл малтай, 26.8 хувь буюу 5305 өрх 101-200 малтай, 27.4 хувь буюу 5431 өрх 201-500 малтай, 6.02 хувь буюу 1194 өрх 501-999 малтай, 1.7 хувь буюу 327 өрх 1000-1499 малтай, 0.2 хувь буюу 37 өрх 1500-2000 малтай, 0.1 хувь буюу 8 өрх 2000-аас дээш малтай байна. Малтай өрхийн бүлэглэлт тус бүрийн нийт малтай өрхөд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 10 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 0.7 пунктээр өссөн, 11-30 хүртэл малтай өрхийн нийт малтай өрхөд эзлэх хувь 1.9 пунктээр өссөн, 31-50 хүртэл малтай өрхийнх 1.21 пунктээр өссөн, 51-100 хүртэл малтай өрхийнх 0.6 пунктээр өссөн, 101-200 хүртэл малтай өрхийнх 0.7 пунктээр өссөн бол 201-500 хүртэл малтай өрхийнх 3.3 пунктээр, 501-999 хүртэл малтай өрхийнх 1.78 пунктээр, 1000-1499 хүртэл малтай өрхийнх 0.1 пунктээр тус тус буурсан, 1500-2000 хүртэл малтай, 2001-с дээш малтай өрхийн хувьд хэвийн түвшинд байна.

Оны эхний малын 19.9 хувь буюу 877.8 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулж, 7.3 хувь буюу

327.1 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэж, 1.8 хувь буюу 78.5 мянган толгой малыг бусдад шилжүүлсэн байна.

Нийт 1933.8 мянган толгой хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 48.1 хувийг эзэлж, өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 2.7 хувиар буюу 53.1 мянган толгойгоор буурсан, нийт малд эзлэх хувийн жин урд оноос 3.7 пунктээр өссөн байна.

Оны эхний төллөх эх малын 58.2 хувь буюу 1157.3 мянган эх мал төллөж, гарсан төлийн 88.5 хувь буюу 1024.1 мянган төлийг бойжуулсан байна.

Оны эхэнд тоологдсон нийт малын 7.3 хувь буюу 328.7 мянган толгой мал зүй бусаар хорогдсон ба хорогдлын 87.5 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 0.7 хувь буюу 2.2 мянган толгой мал өвчнөөр хорогдсон байна.

